

## Тойм ба үндэслэл

<p><b>Үзүүлэлт</b></p>	<p><b>13. Соёл, боловсролоос бусад салбар дахь бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээ нь СББӨ-ийн олон талт байдал, түүнийг хамгаалахын ач холбогдлыг тусган хэрэгжүүлдэг эсэх</b></p>	
<p><b>Үнэлгээний хүчин зүйлүүд</b></p>	<p>Энэхүү үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж, тайланг үндэсний түвшний таван хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг:</p>	
	<p>13.1 Соёлын биет бус өвийг хамгаалах ёс зүйн зарчмууд нь хөгжил дэвшлийн бодлого, төлөвлөгөө болон хөтөлбөрт хүндтэй байр суурийг эзэлдэг.</p>	<p>OD 171(c) EP</p>
	<p>13.2 СББӨ-ийн хамгаалалт болон түүний байдлыг хангахад нийгмийн хүртээмжтэй хөгжил ба байгал орчны тогтвортой байдлыг хангах бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээг шинэчлэн боловсруулж, тогтоож байдаг.</p>	<p>OD 171(d), OD 178, OD 179, OD 181, OD 182, OD 188-190, OD 191</p>
	<p>13.3 Байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд өртсөн СББӨ, үүний нөлөөнд өртсөн хүн ам, иргэдийн тэсвэр тэвчээртэй байдалд СББӨ-н нөлөөлөх чухал нөлөөллийн дагуу арга хэмжээ авах хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээнүүд, бодлогуудыг шинэчлэн найруулж, тогтоож байдаг.</p>	<p>OD 188, OD 191, OD 196</p>
	<p>13.4 СББӨ-ийн хамгаалалт болон түүний байдлыг хангахад эдийн засгийн хүртээмжтэй хөгжүүлэх хууль эрх зүйн болон захиргаааны арга хэмжээнүүд, бодлогуудын шинэчлэн боловсруулж, тогтоодог.</p>	<p>OD 171(d), OD 183-186</p>
	<p>13.5 СББӨ-ийн дадлагажилт, дамжуулалтыг дэмжих ба/эсвэл хөнгөвчлөх, түүний хэрэгжилтэд шаардагдах байгалийн болон бусад нөөцийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн болон төсвийн зохистой</p>	<p>OD 78, OD 186(b)</p>

	<p>хэмжээний арга хэмжээнүүд, урамшууллуудыг бий болгож шинэчлэн боловсруулдаг.</p>	
<p><b>ТХЗ болон бусад холбогдох үзүүлэлтүүд</b></p>	<p><b>Тогтвортой хөгжлийн зорилтууд:</b> СББӨ-ийг хамгаалах нь тогтвортой хөгжлийн бүх биш ч олон зорилгод хувь нэмрээ оруулж чадах учир, энэхүү үзүүлэлт нь 2030 оны мөрийн хөтөлбөрийн ихэнх зорилго, зорилтыг дэмжиж байгаа юм. Гэсэн хэдий ч энэ үзүүлэлт нь тогтвортой хөдөө аж ахуй (ТХЗ 2), эрүүл мэнд, сайн сайхан байдал (ТХЗ 3), биологийн олон янз байдал (ТХЗ 15), тогтвортой усны хэрэглээ (ТХЗ 6) зэрэг бусад зорилтуудад хамааралтай соёл, боловсролоос бусад салбаруудад СББӨ-г хамгаалах ажиллагаанууд болон төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлдгээрээ 11, 12-р шалгуур үзүүлэлтээс ялгаатай юм. Энэ ч утгаараа энэхүү үзүүлэлт нь Тогтвортой хөгжлийн зорилтууд дундаа хамгийн өргөн хүрээний хэрэглэгдэхүүнтэй байх боломжтой юм.</p> <p><b>Бусад үзүүлэлтүүдийн хамаарал:</b> Хөгжлийн хэд хэдэн салбарт өргөн хүрээний бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 13-р үзүүлэлт нь соёлын салбарт чиглэсэн 11-р үзүүлэлт, боловсролын салбарт чиглэсэн 12-р үзүүлэлтүүдийг дэмжиж байдаг. Нөгөө талд нь үзүүлэлт 14 нь салбар бүрийн тодорхой хэмжээний хүсэмжит бодлого, арга хэмжээний нөхцөл байдалд анхаарлаа хандуулдаг. Энэхүү үзүүлэлт нь бодлогын нөхцөлтэй холбоотой хэдий ч 15,16-р үзүүлэлтүүд нь эдгээр бодлогуудыг хэрэгжүүлэх, ялангуяа тогтвортой хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөнд чиглэгдсэн байдаг.</p>	
<p><b>Үйл ажиллагааны үндэслэл</b></p>	<p>Энэхүү конвенц нь улс бүрийг “биет бус соёлын өвийн нийгэм дэх үйл ажиллагааг дэмжих, уг өвийг хамгаалах асуудлыг төлөвлөлтийн хөтөлбөрт тусгахад чиглэсэн ерөнхий бодлого хэрэгжүүлэх”-ийг уриалдаг (13(a) зүйл). Үүний хариуд улс орнууд Үйл ажиллагааны удирдамжийн VI бүлгээс СББӨ-ийн болон тогтвортой хөгжлийг хамгаалах (ODs 170-197) хоорондын харилцааг зохицуулж, олон төрлийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ бодлого, хууль эрх зүй, захиргааны арга хэмжээг хэрэгжүүлэхийг уриалж, тус хөтөлбөрүүдийг удирдан чиглүүлж, үр нөлөөг нь нэмэгдүүлэх ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Хэрэв энэ нь байх аваас цөөн хэдэн улс энэ үзүүлэлт эсвэл холбогдох удирдамжид тусгагдсан бүх салбаруудад бодлогын хөгжлийг нэгэн зэрэг авч үзэх боловч энд тодорхойлогдсон нэг буюу хэд хэдэн салбарт чиглэсэн бодлого, хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээг бий болгох, өөрчлөх нь олонхид ашигтай байх болно.</p>	

<b>Гол нэр томъёо</b>	<ul style="list-style-type: none"> <li>· Бодлого</li> <li>· Хууль эрх зүйн арга хэмжээ</li> <li>· Захиргааны арга хэмжээ</li> <li>· Олон талт байдал (СББӨ болон түүний өвлөн уламжлагч нар)</li> <li>· Соёлын биет бус өвийг хамгаалах ёс зүйн зарчим</li> <li>· Нийгмийн хүртээмжтэй хөгжил</li> <li>· Эдийн засгийн хүртээмжтэй хөгжил</li> <li>· СББӨ-ийн дадлага хийхэд шаардагдах байгалийн болон бусад нөөц</li> </ul>
-----------------------	---

### **Хяналт-шинжилгээ хийх, үе үе тайлагнах тухай тусгай заавар**

<b>Хяналтын ашиг тус</b>	<p>Энэхүү үзүүлэлтийг хянах нь улс оронд СББӨ болон түүний хамгаалалтыг тогтвортой хөгжилд чиглэсэн хууль эрх зүй болон захиргааны арга хэмжээ, бодлогуудад хэр зэрэг нэгтгэж буйг тодорхойлдог. Хэдий бусад үзүүлэлтүүд нь эдгээр бодлогуудын дагуу хөтөлбөр, үйл ажиллагаагаа явуулж буйгаа харуулдаг ч, бодлогын уг сэдвийг буюу, ялангуяа, тухайн улсын СББӨ-ийг гэсэн зовних байдал нь СББӨ-ийг хамгаалах ёс зүйн зарчмуудад нь илэрч байгаа эсэхийг хянах нь чухайл юм. СББӨ-ийн хамгаалалт болон тогтвортой хөгжлийн хооронд олон боломж бүхий харилцаа, холбоос байдаг түүнд хяналт хийх нь тухайн улсад бодлого боловсруулахад шаардлагатай хараахан судлагдаагүй байгаа боломжуудыг олж нээхэд тусалдаг. Харин дэлхийн түвшинд хяналт шинжилгээ хийх нь улс орнууд СББӨ-ийн хамгаалалтын төлөвлөгөөний бодлого боловсруулахдаа хэр бүтээлч сэтгэлгээг тусгаж байгааг илрүүлж, улмаар өөсрдийн туршлага, хэтийн төлөвийг хооронд солилцох боломжтой салбаруудыг нээж өгөх боломжтой юм.</p>
--------------------------	--

**Мэдээллийн эх сурвалж, цуглуулга**

Улс орнууд хөгжил дэвшилтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулдаг янз бүрийн яамдын гишүүдийг багтаасан олон талын салбаруудыг хамарсан зөвлөлдөх байгууллага эсвэл зохицуулалтын механизмыг байгуулах боломжтой. Мөн энэ чиглэлээр баримталж буй бодлогын ерөнхий тоймыг агуулсан Төлөвлөлтийн яам эсвэл Тогтвортой хөгжлийн яам байх боломжтой. Зохицуулах механизм эсвэл тусгай яам байхгүй тохиолдолд хяналт тавих, тайлагнах үүрэг хүлээсэн хүмүүс тогтвортой хөгжлийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг холбогдох яамдын бодлого, хууль эрх зүйн болон захиргааны баримт бичигтэй зөвлөлдөх шаардлага гардаг.

**Боломжит мэдээллийн эх сурвалжууд**

- Албан ёсны сэтгүүл эсвэл хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын эмхэтгэл
- Тогтвортой хөгжилд оролцдог холбогдох яамдын бодлогын баримт бичиг, нарийвчлал ОБ-ын VI бүлэгт дурдсан салбаруудад идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг яамдын баримт бичгүүд.
- Тогтвортой хөгжилд оролцож буй холбогдох яамдын төсөв, санхүүгийн тайлан
- Таван жилийн төлөвлөгөө, арван жилийн төлөвлөгөө гэх мэт үндэсний тогтвортой хөгжлийн стратеги
- ГЭБ (гамшгийн эрсдэлийг бууруулах) үндэсний болон орон нутгийн төлөвлөгөө, ийм төлөвлөгөөний талаарх хяналтын тайлан
- Хөгжил дэвшлийн бодлогыг судалж буй судалгааны хүрээлэнгүүдийн хийсэн судалгаа эсвэл судалгаа